





МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/255

Мандалговь

Цахилгаан дамжуулах шугамын  
ашиглалтын түвшин тогтоох ажлын  
хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын Б заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 сарын 29-ний 79 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн орон нутгийн өмчөөс Төрийн өмчид шилжүүлэх "Цахилгаан дамжуулах агаарын шугам"-ын ашиглалтын түвшин тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Энхбат – Дундговь аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер

Гишүүд: С.Ууганбаяр – Орон нутгийн өмчийн газрын дарга  
Ц.Даваа – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Буянтогтох - Дундговь аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын ашиглалт засварын инженер

Нарийн бичгийн дарга: О.Мөнхзул – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Хоёр. Орон нутгийн өмчөөс Төрийн өмчид шилжүүлэх "Цахилгаан дамжуулах агаарын шугам"-ын ашиглалтын түвшин 2018 оны 6 сарын 7-оос 6 сарын 11-ны хооронд тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0000750